



107

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 114

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтооолор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

Нэг. Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэж авах 30,000,000 /гучин сая/ төгрөгийн балансын үнэтэй Toyota Наисемаркын автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /А.Мөнхбаатар/-т дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын
23. өдрийн 114 тогтоолын хавсралт

Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
шинээр бэлтгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Toyota Haice маркын автомашин	1	30,000,000	30,000,000
			30,000,000 /гучин сая/	30,000,000 /гучин сая/